


БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО:

Боловсролы чиглэлээр:

Гэр бүлийн туршилтын хөтөлбөрт 95 өрхийн судалгаа гаргасан бөгөөд багаар нь задалж үзвэл 1-р баг-15, 2-р баг-0, 3-р баг -12, 4-р баг-12, 5-р баг-12, 6-р баг -13, 7-р баг -5, 8-р баг-5,9-р баг-20. Сумын хамтарсан баг 8 дугаар багийн 2 залуу гэр бүлийн сургууль завсардсан хүүхдийг сургуульд хамруулах, хүүхдийг боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах талаар эцэг, эхийн үүрэг хариуцлага талаар яриа таниулга хийж, зөвлөгөө өгч, 2 хүүхдийг сургуульд хамруулсан.

Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багц нь 10,000-аас дээш хүн амтай хот суурин газруудад хэрэгжиж байгаа бөгөөд тарифтай тоолууртай, цахилгааны утас шаардлага хангасан 0-5 хүртэлх насны хүүхэдтэй, хөгжлийн




бэрхшээлтэй иргэнтэй, ээлжийн болон ажлын 8 цагаар хөдөлмөр эрхэлдэг тус сумын 43 өрхөд нэг бүр нь 3.2 сая төгрөгийн үнэ бүхий багцыг олголоо.

Сумын Засаг даргын 2022 оны А/281 тоот захирамжаар "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл" байгуулсан. Тус зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулаад ажиллаж байна.



Сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл нь аймгийн Насан төвтэй хамтран "орчинд" уралдааны зохион байгууллаа. Монгол Улсын 2003 оны 105 Монгол хэлний хэрэгжүүлэх зарим тухай / 2022-01-05 / хэрэгжилтийг хүрээнд төрийн



туршийн боловсрол Эх бичиг- Цахим удирдамжийн дагуу Уралдааны зорилго: Ерөнхийлөгчийн дугаар зарлиг, тухай хуулийг арга хэмжээний 3Г-ын тогтоолын хангах ажлын байгууллагын цахим

хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ мэдээллийг крилл монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэхэд оршино. Уралдаанд төрийн 12 байгууллагын материал ирж 1 дүгээр сургууль, аймгийн Нийгмийн даатгал, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр зэрэг газрыг амжилттай оролцлоо.

Монгол хэл бичгийн хэрэгжилтийг 19 шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагыг үзэж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажилласан.

Үндэсний бичиг үсгийн баяр тохиолдож буй өдрүүдэд Сүхбаатарчууд Монгол бичгийн 10 төрлөөр өрсөлдлөө. Титэм арт академийн санаачлан эхлүүлсэн тус уралдааныг Баруун-Урт сумын ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газар хамтран зохион байгуулдаг бол энэ жил УИХ-ын гишүүн Жамбын Батсуурь ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон.



Жаахан шаргын нутаг-2023
уралдаан нь Сүхбаатар аймгийн яруу
найрагчид зохиолчдын бүтээлээс
сэдэвлэдэг онцлогтой бөгөөд энэ удаад
Н.Доржцэрэнгийн зохиол бүтээлээр 28



байгууллагын 280 албан хаагч, 11 сургуулийн 424 сурагчийн хичээнгүй бичвэр, мэргэжлийн 34 багшийн сайн туршлага, интерактив даалгавар, тайлан, 80 гаруй уран бүтээлчид бүтээлээ ирүүлсэн.

Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангаж, журамт үүргээ ухамсарлан хэрэгжүүлэх, хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн болон сургуулийн үйл явцад хүүхдийн бүтээлч оролцоог хангах, тэдний дуу хоолойг сонсож, орон нутгийн түвшинд үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхэд зорилгоор “ОРОЛЦЬЁ, ХӨГЖЬЕ-2023” хүүхдийн чуулган зохион байгууллаа. Чуулганд 400 оролцогч хүүхдүүд хамрагдсан. Ерөнхий боловсролын 4-н сургууль дээр 4-н өртөөнд хуваагдах салбар зөвлөл хуралдааныг зохион байгуулж салбар хуралдаанаар хүүхдүүд өөрсдөө тулгамдаж байгаа асуудлыг гарган ирж томчууд болон орон нутгийн удирдлагуудаар асуудлаа дэвшүүлэн шийдүүлсэн хуралдаан боллоо. Чуулганаар хүүхдүүдийн дэвшүүлсэн асуудлыг эрэмбэлэн эхний 13 асуудлаас 3 асуудлыг шийдвэрлээд байна. Үүнд:



ОРОЛЦЬЕ, ХӨГЖЭЭ-2023

хүүхдэн чуулгын хөтөлбөр

ХХТХТХТЭ хэвлэлийн үйл ажиллагаа	Орлогдсон ажил
09:00-10:30	11:00-15:30
НЭГТӨӨ 10:30-12:00 2-д орлого	2-д орлого 14:00-15:30
ХҮҮЛЭ 12:15-14:00 13-д орлого	1-д орлого 14:15-15:30
Байрш 14:15-15:30 2-д орлого	3-д орлого 14:45-15:30
Хүлэглэл оролц 15:00-16:40 11:00-12:30	13:00-14:30 13:00-13:45
Амьтан бүх 15:00-12:30 13:00-13:40	11:00-14:30 13:00-14:30
Доголын тухай 15:00-13:40 13:00-14:30	15:00-12:30 11:00-14:30
Асуулт уялбал 13:00-14:30 11:00-11:45	13:00-13:40 11:00-12:30


10⁰⁰ шиг Д Сүмбэртэгийн талбайн хэвлэлийн үйл ажиллагаа



2.Хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх спортын заалыг үнэ төлбөргүй болгох
3.Массыг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулах.

Аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран "Анзаар" аяны нээлтэд оролцлоо. Анзаар аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн сурагчдад хорт зуршил болон гэмт хэрэгт өртөхөөс өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад Ерөнхий боловсролын 4-н сургуулийн 128 багш, ахлах ангийн 480 хүүхэд хамрагдаж мэдээлэл авсан.

Аймгийн цагдаагийн газартай хамтран "Гэр бүлийн нуугдмал хүчирхийллийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх" баг-7 хоног ажил зохион байгууллаа.



Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 тоот тогтоолоор 2023 оныг "Хүүхдийн хөгжил хамгаалал"-ыг дэмжих болгон зарласан. Энэ ажлын хүрээнд Баруун-Урт сумын ИТХ-ын 2023 оны 16/06 тоот тогтоолоор сумын хэмжээнд долоо хоног бүрийн НЯМ гарагийг гэр бүлийн өдөр болгон зарласан. Уг ажлын хүрээнд цацарсан хайр гэр бүлийн өдрийн нээлтийн үйл ажиллагааг 05 дугаар сарын 14-ний өдрийн ням гарагт тэмдэглэн өнгөрүүллээ. Дээрх арга хэмжээнд Гэр бүл Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, "Жаахан шарга" театр, Биеийн тамир спортын газар, Соёлын урлагийн газар зэрэг мэргэжлийн байгууллагууд хамтран ажилласан. Өдөрлөгөөр дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. Үүнд:

• "Найз байя" аяны нээлт, хамтаар амьдрах соёл, үндэсний хувцсаар гоёх уралдаан, цахим орчинд эерэг уриалга дэвшүүлье уралдаан, open mic, спорт өрөлтийн тэмцээн, гэр бүлийн буухиа тэмцээн, оюун ухааны тэмцээн, бийрэн бичлэг сургалт, хамтдаа зураг зурж сурцгаая сургалт, хамтдаа гар урлал хийцгээе сургалт тус тус зохион байгуулсан

бөгөөд нийт 300 гаруй хүүхэд багачууд 100 гаруй гэр бүл оролцлоо.



Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Баруун-Урт сумын ИТХ,



Сүхбаатар аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумын Засаг даргын Тамгын газар, 9 дүгээр багийн ажлын албатай хамтран "АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛИЙГ БҮТЭЭЦГЭЭ" үйл ажиллагааг 9 багийн ажлын алба гэр бүлээ хамруулан зохион байгууллаа. Өдөрлөг арга хэмжээнд нийт 22 гэр бүл хамрагдаж мэдээ, мэдээлэл авлаа.



Аймгийн ГБХЗХГазартай хамтран эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн гэрээр айлчилж, нөхцөл байдлын, эрсдлийн үнэлгээ хийн, хүүхдүүдэд багц гардуулсан.

2023 оны 2 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд 38 кейс ирж үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй 6 кейс, гэр бүлийн хүчирхийллийн 32 кейсийг хяналтдаа авч хариу арга хэмжээг үзүүлэн ажиллаж байна. Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран кейс хэлэлцүүлгийг зохион байгуулж 2023 онд хамтран ажиллах ажлын чиглэлээ авч ажиллаж байна

Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг сумын Засаг даргын 2022 оны А/281 тоот захирамжаар байгуулагдсан. Дээрх дэмжлэгийн багийн гишүүдийг чадавхжуулах мэдээлэл өгөх хурлыг 6 дугаар сарын 06-ны өдөр сумын тамгын газрын хурлын зааланд зохион байгууллаа. Хуралд сургууль цэцэрлэгийн менежер арга зүйч ХБХ ажиллаж байгаа багш нарын төлөөлөл оролцлоо. Дээрх зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангаж ажиллах ажлын хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилд 1,3,4-р сургуульд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр - 7 хүүхэд, 2,3,11 дүгээр цэцэрлэгт- 9 хүүхэд суралцаж төссөн. 2023-2024 оны хичээлийн жилд Хөгжлийн бэрхшээлтэй 6-н настай шинээр сургуульд орох -3 хүүхэд байна.

Залуучуудын чуулганыг баг тус бүрээр зохион байгуулж байна. Тайлант улирлын байдлаар 9, 4, 6, 3 дугаар багийн ажлын алба залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж 400 гаруй залуучуудыг хамруулан үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож, уралдаан тэмцээн зохион байгуулан нэг өдрийн бүтээлчээр өнгөрүүлсэн.

Баруун-урт сумын 9 дүгээр багийн залуучуудын “Хайлаастын залуус” чуулга уулзалт 4 дүгээр сарын 14-ний өдөр 9 дүгээр багийн ИТХ-ын төлөөлөгч, багийн ажлын алба хамтран зохион байгууллаа. Тус чуулга, уулзалтад:

- Багт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд
- Багийн ажлын албаны тайлан
- Залуучуудын оролцоо сургалт
- 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулга авах
- асуулт/хариулт, санал/хүсэлт гэсэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж багийн 87 залуус оролцож төрийн үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл авч, багт тулгамдаж буй асуудлыг харилцан ярилцсан эерэг үр дүнтэй уулзалт болж өндөрлөлөө.



Соёлын чиглэлээр: “Соёлын бүтээл сар”-ын жилийн ажлын төлөвлөгөөг гарган батлууллаа. Төлөвлөгөөний дагуу монгол хүн-монгол хүүхэд сарын хүрээнд уламжлал цагаан сарын баярын ёс уламжлалыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор “Амар байна уу” нэвтрүүлгийн орон нутгийн BBS телевиз, харьяа төсөвт байгууллагуудтайгаа хамтран хийлээ. Нийт 16 байгууллагын 300 гаран ажилтан албан хаагч хүүхэд багачууд хамрагдсан. Нэвтрүүлгийг 5300 иргэн үзсэн хандалттай байна.

Мөн амар байна уу байгууллагын сар шинийн нэвтрүүлэгийг мэргэжилтнүүдээс санаачлан зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Тамгын газрын 47 албан хаагч, 23 байгууллагын ахмад настнууд, харьяа төсөвт байгууллагууд удирдлагууд оролцож 5 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулж, үндэсний өв соёлоо сурталчилан, түгээн дэлгэрүүлж ажилласан. Мөн арга хэмжээнд оролцсон байгууллагын ахмад настнууд болон харьяа төсөвт байгууллагууд удирдлагуудад сар шинийн мэнд хүргэж хүндэтгэл үзүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр “Сүрьеэг устгаж чадна” сургалтыг зохион байгуулсан сургалтад МСҮТ-ийн 35 хүүхдэд,

“Сүрьеэ гэж юу вэ”, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх сургалтад 1-7 дугаар багийн 120 иргэн тус тус хамрагдсан.



Энэрэлт ачтан ӨМТөвд зорилтот бүлгийн 30 хүнийг дох, тэмбүү, В, С вирус шинжилгээнд хамруулж, “БЗДХ-ын шинж тэмдэг, эрсдэлт хүчин зүйл, урьдчилан сэргийлэлт” сэдэвээр сургалт зохион байгуулж сургалтаа бататгах зорилгоор сорил авч, гарын авлага тараасан.

Энхлэн ачтан Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран МСҮТөийн 31 суралцагчдад “Өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулсан. Баруун-Урт суманд амьдардаг эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэ, БЗДХӨ-ний үзлэг шинжилгээ, эрт илэрүүлэх, оношлох, эмчилгээнд хамруулах хүндрэл нас баралтаас сэргийлэх, иргэдэд эрүүл мэндийн чиглэлээр мэдээллийг хүргэх ирлүүлэлтийг хүргэх зорилготой 1-9 дүгээр багийн эрсдэлт бүлгийн 994 хүн амын судалгааг гарган хаяг байршил, утасны дугаарыг тодруулж эрт илрүүлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Үзлэг шинжилгээнд 349 хамрагдсанаас 0-16 насны 78 хүүхдэд туберкулины сорил тавьсанаас 2 хүүхэд урьдчилан сэргийлэх эмчилгээнд орсон. Рентгенд 349 хүн хамрагдаж нийт 24 хүн өөрчлөлттэй, Үүнээс 3 сүрьеэгийн шинэ тохиолдол илэрсэн. Өдрийн эмчилгээнд 3 хүн хамрагдсан.

Нийт 246 хүнд хурдавчилсан оношлуураар шинжилгээ хийснээс:

- ХДХВ/ДОХ-113 хүн хамрагдаж 7 тэмбүү илэрснээс 3 шинэ тохиолдол бүртгэгдсэн.
- В вируст гепатитын шинжилгээнд нийт 89 хүн хамрагдсанаас 1 шинэ тохиолдол илэрсэн.

- Хеликобактерийн шинэилгээнд нийт 121 хүн хамрагдсанаас 23 илэрсэн.
- Бүдүүн гэдэсний маркерийн хурдавчилсан



оношлуураар нийт 35 хүнд шинжилгээ хийснээс 1 илэрч лабораторийн шинжилгээгээр баталгаажуулан хавдрын эмч рүү илгээсэн.

- Элэгний маркерын шинжилгээнд 33 хүн хамрагдсанаас 1 илэрсэн.
- Түрүү булчирхайн маркерын шинжилгээнд 27 хүн хамрагдсан.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран " Эрүүл бие Жаргалтай амьдрал" нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж нийт 257 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулсан.Тус арга хэмжээний үеэр 138 иргэнд харшилаас урьдчилан сэргийлэх,харшлын үед анхаарах нь асуудал сэдвээр сургалт зохион байгуулсан.

Гепатитгүй Монгол төсөлд хамрагдаагүй үлдсэн 2600 иргэний нэрсийн жагсаалтыг гарган багийн ажлын албаар дамжуулан оршин суугаа хаягийг тодруулах ажлыг зохион байгуулсан.

Иргэдийг илрүүлэг үзлэгт хамруулах ажлыг идэвхижүүлэх зорилгоор Иргэдэд үйлчлэх төвийн байранд 66, явуулаар 180 иргэнээс В,С вирусын шинжилгээг авч АНЭ-ийн лабораторид явуулсан байна.

Элэгний С вирус илэрсэн 405 иргэн, гепатитгүй монгол төслөөс илэрсэн С вирустэй 33 иргэнийг ачаалал тоолуулах эмчлүүлэх арга хэмжээг авч ажилласан. 2023 онд В,С вирусын илрүүлэг шинжилгээнд 246 иргэн хамрагдсан.

15-49 насны нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн 4184 бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 2171 эмэгтэй хамрагдсан.

1.Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг-1896.

4.Умайн хүзүүний эрт илрүүлэг-435

5.Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт-735

Өвчлөлөөр ангилвал

Эмнэлзүйгээр эерэг илэрсэн 7, Хөхний хавдрын өндөр эрсдэлтэй бүлгийн эмэгтэйчүүд 22

Хоол боловсруулах тотолцоо өвчлөл-15

Хавдар бус өвчний сэжгээр-22

Шээс бэлгэсийн тотолцооны өвчлөлөөр-23

Бусад -23 байна.

Засаг даргын А/122 захирамжаар 2-5 насны хүүхдүүдийн Нархан сувиллыг ажиллуулж эхлээд байна.Сувилалд хамрагдах зорилтот 60 хүүхдийн нэрийг жагсаалтаар авч, 3 ээлжид хувиарлан эцэг эхэд мэдээлэл өгч ажилласан.Тайлант жилийн хугацаанд хувилбарт цэцэрлэгийн 20 хүүхэд болон иргэдийн санал хүсэлтийн дагуу нэмэлтээр 80 хүүхдийг хүлээн авч нийт 160 хүүхдийг бүртгэн 3 ээлжээр сувилалд хамруулж байна.



Нархан Сувилалд өдрийн 5 удаагийн эмчилгээний хоол, бүтэн биений бариа, бумба тавих, хар цай, шар сүү, ясны шөлөнд оруулах, элс нарны эмчилгээ хийх зэрэг үйл ажиллагаа явагдаж байна.

Швейцарын Хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилттэй МАСАМ-2 төслийг Гэр Бүлийн Сайн Сайхны нийгэмлэг “Хараа Хүрэхүй” ТББ хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Сайн эмнэлэг-Сэтгэлд нийцсэн үйлчилгээ аргачлал боловсруулах сургалтад өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, нийгмийн ажилтан нарыг хамруулж, аргачлалын дагуу Энэрэлт ачтан өрхийн эрүүл мэндийн төвд материаллаг засаглал, сэтгэл зүйн орчинд хөндлөнгийн үнэлгээ хийсэн ба сэтгэлзүйн орчин-68%, засаглалын орчин 75,4% материаллаг орчин 70,3%-тай тус тус үнэлэгдсэн.

Хүүхдийн харааг эрт, зөв үр дүнтэй шалгаж сохрол сул хараанаас сэргийлэх ажлын хүрээнд харааг хэрхэн зөв шалгаж ямар тохиолдолд яаралтай нүдний эмчид илгээх сэдэвтэй сургалтыг зохион байгуулсан.

Дэлхийн Өрхийн эмнэлгийн баярын өдрийг тохиолдуулан Өрхийн эрүүл мэндийн төвийн 5 албан хаагчийг Засаг даргын баярын бичиг, 2 албан хаагчийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын хүндэт өргөмжлөлөөр тус тус шагнаж урамшуулсан.

Баруун-Урт сумын 7-р багийн аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн санаачилга, дэмжлэгтэйгээр “Зөв хэвшил-Зөв амьдрал хөтөлбөр”, Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн хүрээнд “Эрүүл мэнд-Эрхэм баян” эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгуулж иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл мэндийн боловсрол олгож, мэдлэг мэдээлэл өглөө. Уг ажлын хүрээнд:

Хүүхдийн амны хөндийн үзлэг, оношилгоо, эрдэсжүүлэх түрхлэг

Эрүүл мэндийн боловсрол, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх

Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө

Дотрын эмчийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө

Цусанд сахар үзэх оношилгоо



Хэвлийн хөндийн Эхо, оношилгоо хийлээ. Арга хэмжээнд 59 хүүхэд, насанд хүрсэн 75, нийт 137 иргэн хамрагдсан. Өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхдүүдэд дархлаажуулалтын багц олгон, монос эмийн сангаас эмийн зохистой хэрэглээ, эм витамин танилцуулгыг иргэдэд хийж хамтран ажиллалаа.

Спортын чиглэлээр:

Баруун-Урт сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан Монгол Улсын гарамгай начин Л.Дашдаваа агсаны нэрэмжит “Зодогтой багачууд” бөхийн тэмцээн зохион байгуулагдаж Баруун-Урт сумын хүүхдийн 11 цэцэрлэгийн, 64 хүүхэд хамрагдан авхаалж самбаа, хүчээ бяраа сорьж оролцлоо.

Зөв хэвшил-Эрүүл амьдрал аяны хүрээнд иргэдийг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, илүүдэл жин таргалалтыг бууруулах, эрүүл идэвхтэй амьдрал, зөв дадал хэвшүүлэх зорилгоор “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” бүх нийтийн крос гүйлтийг 2023 ны 04 дүгээр сарын 22-ны өдөр Мал эмнэлгийн газар, Өсөх дэлгэр ундрах, 2-р бүрэн дунд сургууль хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 24 аж ахуйн нэгж, иргэн,

албан байгууллагын 470 гаруй хүн хамрагдсан. Арга хэмжээнд гүйлт, алхалт, дугуй унах, дасгал хөдөлгөөн хийж оролцсон ба 4 байгууллага нийт 450,000 төгрөгийн витаминаар 470 хүнийг витаминжуулсан.

Баруун-Урт сумын хүүхэд багачуудыг усан спортоор хичээллэх сонирхлыг дэмжих, устай зөв харьцах суурийг нь эхнээс нь зөв системтэй сургах, цаашид өөрийгөө болон өрөөл бусдыг гол ус, үерийн аюулаас хамгаалах эрсдэлийг даван туулах чадвартай болох мөн нутгаасаа олон арван шилдэг тамирчид бэлтгэн гаргах зорилтыг тавин “Би сэлж сурлаа” хөтөлбөрийг хэрэгжүүлж 400 хүүхэд хамруулаад байна.



“Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийн хүрээн аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 27-ны бямба гаригт “Баруун-Урт Марафон-2023” амжилттай зохион байгуулагдлаа.

Тус марафонд 18 наснаас доош 3 насны ангилал, 19-29 насны ангилал, 30-39 насны ангилал, 40 дээш насны ангилалаар 113 тамирчин өрсөлдөж, хурд хүчээ сорилоо.Үүнд:

18-аас доош насны эмэгтэй төрөлд:

1-р байр: М.Анужин /МСҮТ/
2-р байр: Х.Хүсэлзаяа /4-р сургууль/
3-р байр: Б.Эрдэнэчулуун /Дарьганга сум/



18-аас доош насны эрэгтэй төрөлд:

1-р байр: Т.Энхбаяр /МСҮТ/



2-р байр: Х.Нямдорж /1-р сургууль/
3-р байр: С.Мөнхбат /2-р сургууль/



19-29 насны эмэгтэй төрөлд:

1-р байр: Хонгорзул /МСҮТ/

2-р байр: Нарансолонго /МСҮТ/

3-р байр: У.Үүрцайх /МСҮТ/

19-29 насны эрэгтэй төрөлд:

1-р байр: Н.Баяржаргал /ОБГ/

2-р байр: Б.Очироо /Дорнод аймаг/

3-р байр: Б.Бямбасүрэн /Цагдаа/



30-39 насны эмэгтэй төрөлд:

1-р байр: Э.Мөнхтуяа /Хөлбөмбөгийн холбоо/

2-р байр: Б.Наранцэцэг /Хувиараа/

3-р байр: Г.Дэлхийцэцэг /ХБ холбоо/



30-39 насны эрэгтэй төрөлд:

1-р байр: А.Нямбаяр /Цайрт/

2-р байр: Б.Золбаяр /Хилийн цэргийн 0184-р анги/

3-р байр: Б.Баярболд /ШШГА/



40 дээш насны эмэгтэй төрөлд:

1-р байр: М.Мөнхдэлгэр /ОБГ/

2-р байр: Мөнхцэцэг /ОБГ/

3-р байр: Л.Энхсайхан /Ундрах-18/



40 дээш насны эрэгтэй төрөлд:
 1-р байр: Г.Батсургар /Болосрол өргөө/
 2-р байр: О.Цэвээнжаргал /ОБГ/
 3-р байр: Б.Базориг /ДБЭХС/ тус тус шалгарав.



Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2023 оны А/161 дүгээр захирамжаар “Эрүүл аюулгүй ажлын байр”-Бидний суурь эрх” уриан дор зохион байгуулж буй “ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян 2023” арга хэмжээний хүрээнд “Баруун-Урт сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

“Эрүүл аюулгүй ажлын байр”-Бидний суурь эрх” уриан дор зохион байгуулж буй “ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2023” аянд нэгдэхийг уриалж постер болон аяны хүрээнд хийгдсэн ажлыг Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын Засаг даргын тамгын газар цахим хуудсанд байршуулсан.

Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч нарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон зам тээврийн осол гэмтэл, хүнсний аюулгүй байдал, ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах уулзалтыг зохион байгуулсан. Арга хэмжээнд 40 аж ахуйн нэгж оролцож, мэдээ, мэдээлэл олж авсан.

Аймгийн Онцгой байдлын газар, ДБЭХС ТӨХК-Сүхбаатар эрчим, Дөрвөлж ОНӨААТҮГ-тай хамтран төсөвт байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд хяналт хийж галын болон цахилгааны аюулгүй байдал цэвэр бохирын шугам, сүлжээнд гарсан зөрчлийг илрүүлж зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Нийт 40 байгууллагын 13 зөрчлийг илрүүлж зөвлөмжийг өгч зөрчлийг арилгуулсан.

Аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс МҮЭХ-ны хөдөлмөр сургалт, судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан. ХАБЭА болон Хөдөлмөрийн хууль тогтоомжийн сургалтад салбар зөвлөлийн гишүүд цахимаар хамрагдсан.

Хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах 3 талт хороонд хөдөлмөрийн харилцаатай холбоотой 4 гомдол ирсэн. Хороо 5 удаа хуралдан хэлэлцэж 2 гомдлыг аймгийн захиргааны хэргийн шүүхэд шилжүүлж, 2 гомдолд талуудыг эвлэрүүлэн зуучилсан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 16/07 тоот тогтоолоор малчны залуу халаа хөтөлбөрийг баталсан.Тус хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 7 залуу малчин өрхийг судалгаа өнөөдрийн байдлаар 1 өрх дэмжигдээд байна.

Нийтийн хамарсан төслийн хүрээнд Баруун-Урт сумын Засаг Даргын Тамгын газраас 4 төсөл илгээсэн.Үүнд:

1. Шарилжгүй Баруун-Урт
2. Хоггүй Баруун-Урт
3. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх
4. Ногоон-Баруун-Урт Энэхүү 4 төслөөс 3 төсөл шалгарсан.

Нийтийг хамарсан төслөөр Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас 50 иргэнг хамруулан түр ажлын байраар ханган ажилласан. Одоогийн байдлаар : Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд 10 иргэн ажилуулсан..

Ногоон Баруун-Урт төслийн хүрээнд 30 иргэн хамруулахаас хаврын улиралд 14 иргэн, намрын улиралд 16 иргэн ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зорилтод бүлгийн болон байгалийн гамшигт өртсөн айл өрхүүдэд дэмжлэг туслалцааг үе шаттайгаар хүргэн ажиллаж байна. Үүнд:

Дизерт Олон Улсын байгууллагаас 100 малчин өрхөд тусламж дэмжлэг,

МУЗН нь өвөлжит хүндэрсэн 10 малчин өрхөд 3 сая төгрөгний бэлэн мөнгөний дэмжлэг,

1000 сэтгэл аяны хүрээнд хандивт нэгдсэн хувь хүн болон аж ахуй нэгжүүдээс цугласан эд бараа, 6 сая төгрөгийг байгалийн гамшигт өртсөн 130 өрхөд дэмжлэг,

Орон гэргүй болон байгалийн гамшигт нэрвэгдсэн 7 иргэнд 4 хантай гэрийг тус тус олгосон байн.

Тусгай хэрэгцээт иргэдийг соён гэгээрүүлэх, нийгэмшүүлэх, эрх хөгжил хамгааллыг нь дэмжих зорилготой хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд боловсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагатай "Тэгш боломжийг хамтдаа" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.Арга хэмжээнд аймгийн Үйлдвэрчний эвлэл, Гэр бүл сайн сайхны нийгэмлэг, Хөл бөмбөгийн холбоо, Шатрын холбоо, Сийлэнгоо эмэгтэйчүүдийн клуб, Ахмадын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг иргэний нийгэмлэгийн 7 байгууллага болон 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцож санал санаачилга, ажлын санал зэргийг хэлэлцэн ярилцаж хамтран ажиллах шийдвэрт хүрсэн..

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 4 удаа хийж, асаргаа шинээр тогтоолгох 12, асаргаа сунгах 35, асран хамгаалагч солих 2, 0-18 хүртлэх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тэтгэмжинд 1 иргэн, ОНОТХҮйлчилгээний төсөл хөтөлбөрт 10 бүлгийн төсөл, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжинд 2 иргэн, малжуулах төсөлд 5 малчин өрхийн төслийг тус тус дэмжиж хамруулаад байна. Мөн өдрийн үйлчилгээнд хамрагдах 20 ахмадын нэрсийг хэлэлцсэн. Шинэ төрсөн хүүхэд-69, цалинтай эхийн тэтгэмжинд-31, жирэмсэн эхийн тэтгэмжинд -31, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт шинээр орж байгаа болон сунгагдсан-17, утасны хөнгөлөлтөнд 7, ихэр хүүхдийн тэтгэмж 1, оршуулгын тэтгэмжинд 2 иргэн, ахмад настны хөнгөлөлтөнд 28 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 6 иргэнийг тус тус бүртгэн нөхөн олголтыг бүрэн хийж гүйцэтгэлээ. Хүүхдийн мөнгөтэй холбоотой биеэр ирсэн 5, утсаар 1, цахимаар 7 иргэнд зөвөлгөө мэдээлэл хүргэн ажиллалаа. 2022 оны хүүхдийн мөнгөний

нөхөн олголт хийгдэхтэй холбоотой 55 хүүхдийн мэдээллийг тулгаж 18 хүүхдийн нөхөн олголтыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Баруун-Урт сумын нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, зорилтот бүлгийн 3 өрхөд хандивлагч 3 иргэний хүсэлтээр тохирох өрхүүдийг сонгож, тусламжид хамрууллаа. Үүнд: 1. Баруун-Урт сумын 9 дүгээр багийн олон хүүхэдтэй 1 өрхөд хонь, нэг хүүхдийг иж бүрэн хувцасласан. 2. Баруун-Урт сумын 1 дүгээр багийн иргэн олон хүүхэдтэй 1 өрхөд хонь өгсөн. 3. Баруун-Урт сумын 8 дугаар багийн 4 хүүхэдтэй өрх толгойлсон эхтэй өрхийн хүүхдүүдэд нь өмсөх хувцас, хүнсний бүтээгдэхүүний тусламж үзүүлсэн.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Худалдаа, үйлчилгээний чиглэлээр:

Орон тооны бус зөвлөлд хагас жилийн хугацаанд цагдаагийн газар зөрчлийн хэрэг нээгдэн шалгагдаж байсан зөрчил бүхий 7 материал ирүүлсэн. Тус сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөл 7 удаа хуралдаж 174500 мянган төгрөгийг улсын орлого болгон ажиллаж хугацаа дууссан 42500 мянган төгрөгний барааг устгаж, тамхины хяналтын тухай хууль зөрчиж насанд хүрээгүй иргэнд тамхи худалдан борлуулсан 3 аж ахуй нэгжийн зөвшөөрлийг захирамжаар цуцлан холбогдох хуулийн дагуу ажилласан. Эрх бүхий албан тушаалтны ирүүлсэн албан тоотын дагуу хугацаанд нь хуралдаж шийдвэрийг гарган ажилласан.

төвийн захирал хамтран сонирхолтой		Г.Эрдэнэгэрэлтэй сургалт зохион	
байгуулагдлаа. иргэн хамрагдлаа.		Сургалтад 51	
Баруун-Урт сумын сангаас 11 иргэн, төгрөгний зээл олголоо.		хоршоо хөгжүүлэх ААНэгжид 380 сая	

ХХААХҮЯамны сайдын А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж Сумын ИТХ-аас тогтоосон товын дагуу хоршоо болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 08:30 цагаас өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08:30 цаг хүртэл хүлээн авсан.

Тогтоосон товын хугацаанд иргэн, аж ахуй нэгжээс 33 төсөл ирүүлсэн бөгөөд төсөл сонгон шалгаруулах зөвлөл 04 сарын 25-аас-29-ний өдрүүдэд 3 үе шаттай хуралдлаа.

Нэгдүгээр шат: Дүн шинжилгээ хийх :

1. Баруун-Урт сумын иргэн, ААНэгж, хоршоо эсэх
 2. Сумын тэргүүлэх чиглэлд нийцсэн эсэх,
 3. Санхүүгийн тооцоолол бодитой эсэх,
 4. Монгол банкны мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх
 5. Шүүхийн шийдвэр, татвар зэрэг холбогдох газрын лавлагаа
 6. Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй эсэх
 7. Төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой
 8. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн эсэх
- Хоёрдугаар шатанд шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийн бодит нөхцөл байдалтай газар дээр нь очин танилцаж, шинжилгээ хийсэн.

Гуравдугаар шатанд төсөл хэрэгжүүлэгч төсөл сонгон шалгаруулах зөвлөлд өөрийн төслийг танилцуулсан.

ХХААХҮЯамны сайдын А/361 тоот тушаалаар батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын шаардлагыг хангасан дараах төслүүд дэмжигдэж 380 сая төгрөгийн зээл авлаа.

1. М.Төрбаяр - Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй- 40,000,000
2. Х.Хатанбаатар - “Аргалын утаат борц” Мах махан бүтээгдэхүүн боловсруулах - 40,000,000
3. Г.Өлзийтогтох – “Талыг Монгол борц” Мах махан бүтээгдэхүүн боловсруулах - 40,000,000
4. Т.Идэрбаяр - Бууз, баншны үйлдвэрлэл - 25,000,000
5. Н.Амартайван- Дарьганга хийц урлал- 15,000,000
6. С.Лхасүрэн-Модоор урлал хийх- 20,000,000
7. Л.Эрдэнэдалай - Модны үйлдвэрлэлийн өргөтгөл- 40,000,000
8. Б.Содхүү - Тавилга үйлдвэрлэл - 40,000,000
9. Наран булаг принт ХХК /Ц.Үүрцайх/ – “Сайран хөлт” оймс үйлдвэрлэл 40,000,000
10. “Цагаан хүч” ХХК /М.Мөнхтулга/ - Шүдний эмнэлэг тоног төхөөрөмж - 40,000,000
11. “Дөхөм өндөр” ХХК /Д.Ням/ -Металл цонх үйлдвэрлэл-40,000,000

Дашрамд дурдахад :

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл:

- Зээлийн зориулалт: Үндсэн хөрөнгө оруулалт
- Зээлийн хугацаа: 5 хүртэл жил
- Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 12 хүртэл сар
- Зээлийн хүү: 3 хувь

ЗЭЭЛ ОЛГОХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

- 1.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэл
2. Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр;
3. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэлт
5. Ноос, ноолуур угаах үйлдвэрлэл
6. Малын тэжээл тариалалт, үйлдвэрлэл
7. Арьс, шир дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл
8. Барилгын материал үйлдвэрлэл
9. Нийтийн ахуйн үйлчилгээ
10. Хог хаягдал хоёрдогч түүхий эд дахин боловсруулах үйлдвэрлэл
11. Аялал жуулчлал
12. Орон нутагт хэрэгцээт, шинэлэг дэвшилтэд техник, технологи үйлчилгээ, үйлдвэрлэл.



Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйлчилгээний стандарт бараа бүтээгдэхүүний чанар стандарт,

тохижилт үйлчилгээнд хяналт тавих зөвлөн туслах зорилгоор Цагаан сар нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу 26 аж ахуйн нэгжээр хяналт шалгалтын ажил зохион байгууллаа. Хяналт шалгалтын явцад 15 нэр төрлийн барааны хадгалах хугацаа дууссаныг илрүүлж холбогдох зөвлөмж өгч лангуунаас хураан авч иргэдэд чанар стандарт хангасан нэр төрлийн барааг худалдахыг зөвлөлөө.

Эх үрсийн баярыг тохиолдуулан хоол, хүнсний гаралтай хordлого, халдвараас



урьдчилан сэргийлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж буй хүнсний худалдаа, талбайн ойр нийтийн хоолны газруудад зөвлөн туслах хяналт шалгал хийлээ. Нийт 15 иргэн аж ахуй нэгжид зөвлөмж өгч ажиллаж байна. Уг хяналт шалгалтаар Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран ажиллалаа.

Сумын хэмжээнд бүртгэлтэй 14 хоршоо байгаагаас идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 2 хоршоо байна. Үүнд Түмэн цагаан ноос хоршоо, Алтан цацал хоршоодууд байна. 14 хоршооны мэдээллийг шинэчлэн Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Б.Баттуяатай хамтран хоршоодын үйл ажиллагааг чадавхжуулах тал дээр анхаарч ажиллан сургалт зөвлөгөө, арга зүйн зөвлөгөөг 5 хоршоонд өгөөд байна. Сургалтын үр дүнд манай суманд оёдолчид нэгдэн Бумт алтан шаглаа хоршоо байгуулагдан үйл ажиллагаагаа явуулаад байна.

Орон нутгийн ЖДҮҮ эрхлэгчид, аймаг, сумдын ЖДҮҮ асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдийн бизнесийн маркетингийн мэдлэг, туршлага нэмэгдүүлэх, орон нутгийн болон Канадын бизнес эрхлэгчдийн маркетингийн туршлагаас суралцах уулзалт зохион байгуулагдсан.

MERIT төслийн зөвлөх Эрик Карлзен Канадын хоршооны маркетингийн туршлага, зохион байгуулалтын талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан. Мөн Хоршоодыг чадавхжуулах зорилгоор АНУ-аас санхүүжилттай БЭСТ хөтөлбөр, Канадын засгийн газраас дэмжлэгтэй МЭРИТ төсөл мөн аймгийн хоршоологчдын холбоотой хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж 44 иргэн, аж ахуй нэгжийг хамруулж зөвлөн туслах чиглэл өгч ажиллалаа. Тус сургалтын үр дүнд оёдолчид нэгдэн нэгдсэн хоршоо байгуулахаар болсон.

Хөдөө аж ахуй чиглэлээр:

Бэлчээрт шинээр гүн өрмийн худгийг 2022 онд 2-г шинээр гаргахаар захиалга өгч 2023 онд гүйцэтгүүлэх төлөвлөлттэй байсан. 2023 оны 05-р сарын 25-ны өдөр "Төв дрилинг" ХХК нь Сүхбаатар сумын 4-р багийн нутаг дэвсгэр Зараагийн чулуу гэдэг газарт нутаглаж буй тус сумын 8-р багийн малчин Сүхболдын суурьт гарч 5000 мал, Сүхбаатар сумын 4-р багийн нутаг дэвсгэрт байрлах Цагаан чулуут гэдэг газарт нутаглаж буй тус сумын 8-р багийн малчин Гантогоогийн суурьт худгийг гаргаж 5000 малыг усан хангамжаар хангасан.



Тус сумын малчдын нутаглаж буй Сүхбаатар сум Уртын голын эх, Уулбаян сумын Хөөвөр, Мөнххаан Наран сарангийн тал зэрэг нутагт үлийн цагаан оготно ихээр тархсан нийт 3000 га талбайд



сумын Засаг даргын 2023 оны А/125 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдож 05-р сарын 08-ны өдрөөс 05-р сарын 11-ний өдрийн хугацаанд устгалын ажлыг зохион байгуулсан. Устгалын ажилд Тамгын газрын 3 албан хаагч, сумын Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн аврах бүлгийн 15 албан хаагч, малчдын төлөөлөл 25 иргэн, тээврийн

хэрэгсэл 3 дайчлагдаж ОНХСангийн хөрөнгөөр 586,900 төгрөгийг зарцуулж ажилласан. Тус ажилд аймгийн ХХААГазраас 2,1 тн хордуулсан будаа хорыг олгож цацах ажил хийсэн.

Уртын голын эхийг хамгаалах зорилгоор 15 га талбайн 650 м газрыг хашиж хамгаалах ажлын саналыг НҮБ-н ногоон сангаас хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг сайжруулах нь" төсөлд танилцуулж 45324773 төгрөгийн дэмжлэг авч тендер зарлагдаж "Хүрэл соёмбо"ХХК шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэж суулгалтын ажлыг тус Тамгын газар, ЗХ-ний 338-р ангитай хамтран хийж гүйцэтгэсэн.



Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд" Бэлчээрийн асуудлаар " УИХ, ХХААХҮЯ, БОАЖЯ, АЗДТГ-с хэлэлцүүлгийг Сүхбаатар суманд 4-р сард зохион байгуулагдсан ба тус хэлэлцүүлгээр төвийн сумын 1076 малчин өрхийн эрх ашгийг хамгаалах талаар хуулийн тусгах, бэлчээрийн бүлэгт онцгой анхаарах зэрэг асуудлаар санал хүсэлтийг тавьсан. Тус хэлэлцүүлэгт Сумын Засаг дарга, 8-р багийн засаг дарга, 30 гаруй малчны төлөөлөл оролцож санал хүсэлтээ хэлсэн.



Сүхбаатар сумын 5-р багийн Иргэдийн Нийтийн Хуралд сумын Засаг даргын орлогч, 8-р багийн Засаг дарга нартай хамтран оролцож малчдын тулгамдсан асуудал, бэлчээр усан хангамжийн талаар санал солилцож зөвшилцөн ажиллаж байна. Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг малчдын сууриар 3 удаа ажиллаж нийт 500 гаруй малчин өрхүүдтэй уулзаж санал хүсэлтийн авсан.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны А/518 дугаар тушаал, Сүхбаатар аймгийн Баруун урт сумын Засаг даргын 2023 оны 02сарын 27ны өдрийн А/48 дугаар захирамжаар 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04-р сарын 01-ны хооронд "Мал амьтны сэг зэм, орчны бохирдол хог хаягдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажил хийгдсэн. Үүнд.

Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 1 ковш, 1 кама, 2 жолооч, Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын 1 суудлын автомашин, 1 ариутгалын ДУК машин, 2 мэргэжилтэн, 1 жолооч, 2 туслах ажилтан ажиллаж, 3,205,900 зарцуулсан. Дээрх нөхцөл байдлыг арилгах нөхөн сэргээх ажлын хүрээнд 05-р сарын 23-28-ны өдрийн хооронд "Мал амьтны сэг зэм, орчны бохирдол хог хаягдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж үр дүнд хүрсэн.

Малын сэг зэм устгал, бэлчээр цэвэрлэгээ ариутгалын тайлан Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны А/518 дугаар тушаал, Сүхбаатар аймгийн Баруун урт сумын засаг даргын 2023 оны 02сарын 27ны өдрийн А/48 дугаар захирамжаар 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04-р сарын 01-ны хооронд "Мал амьтны сэг зэм, орчны бохирдол хог хаягдлыг цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж үр дүнд хүрсэн.



1,2,3-р гуу, хуучин агро парк, клонк, цэвэрлэх байгууламж, хогийн цэгийн урд хэсэг, Уртын голын эх, Таван эрдэнэ малтай хороолол, Өлгий зэрэг нийт 10 хэсэг газарт үхсэн малын сэг зэм, бэлчээрт үүссэн эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн. - 25000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдсэн. Сүхбаатар сумын 4-р багийн нутаг дэвсгэр Хүүхдийн худаг гэдэг газарт 8-р багийн малчин М.Ганбатын суурьт малын гоц халдварт цэцэг өвчин гарсан ба бэлчээрийн ариутгалыг 11 хот айлын 10000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдсэн. Устгалын нийт 11 цэгт үхсэн малын сэг зэм, бэлчээрт үүссэн эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн. нийт 1000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдсэн.

АДАРТ Олон Улсын байгууллагаас "өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг хадгалах агуулах, саравч шинээр барих ажлыг ХАА-н цогцолборт эхлүүлж суурь цутгалтын ажил хийгдэж байна. Тус ажлын Молцог элс ХХК гүйцэтгэлийн ажлыг хийж байна. Ажлын гүйцэтгэл 40хувьтай байна.

Байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж хөрсөн дээр хүйтрэлт ихтэй байгаа тул тариалалт оройтож хийгдэж байна. 05-р сарын 25-ны өдрийн байдлаар 7 га талбайд төмс тариалсан байна. Алтанцацал хоршоо 5 га, ХХААГазар 2 га талбайд тариалсан. Хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах үүднээс ХХААХҮЯамнаас хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулсан дээрх хөнгөлөлтөд нийт 5 төрлийн үрийг 10 иргэнд олгосон байна. Сумын ЗДТГ-н харъяа Хөдөө аж ахуйн цогцолбор нь төмс хүнсний ногоо тариалах хүсэлтэй амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 10 өрхийн 10 иргэнд ногоо тарих талбай, усалгааны системийг шийдвэрлэж өгсөн. Өрхийн тариалан эрхлэгчдийн мэдээллийг цуглуулж тариалангийн нэгдсэн систем plant.mofa.gov.mn цахим системд оруулж, урамшуулал, дэмжлэг авах системд нэвтэрч мэдээлэл авах заавар зөвлөгөө өгч ажилласан ба энэ онд 5 иргэн бүртгэлд хамруулсан байна.

Баруун-Урт сумын ЗДТГ-ын мэдэлд хуучин 1 га талбай бүхий агропаркийн талбай байсан ба тус талбайн усан хангамж дутагдаж төмс хүнсний ногоо тариалах боломжгүй болсон тул ХАА-н цогцолбортой нийлүүлэх цаашид хөгжүүлэх бодлогын хүрээнд хуучин агропаркийн талбайн эд хөрөнгө худаг, 1 га талбайг хашсан блокон хашаа, 6*8 м харьцаатай агуулах зэрэг өмчийг нүүлгэн шилжүүлэх талаар аймгийн өмчийн албанаас Аймгийн ИТХ-д санал оруулж дэмжигдсэн. ХАА-н цогцолборт төмс хүнсний ногоо, ногоон тэжээл тариалалт хийх талбайн хагалгаа, үрэлгээ хийх зорилгоор Нараншарга агро ХХК-тай 12,0 сая.төгрөгийн шууд ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хагалгааны ажлыг хийж

иргэд нийт 0,8 сот газарт төмс, 0,1 сот газарт ногоон сонгино, 0,1 га талбайд хүнсний ногоо тариалсан.

ХАА-н цогцолборын талбайг тэлж 25 га талбайд үйл ажиллагаа явуулах ба Ногоон тэжээлийг тариалах талбай 2022 онд 7,5 га талбай байсан бол 2023 онд нэмэлтээр 12,5 га атар газрыг нэмж хагалж нийт 20 га талбайд тариалахаар газар хагалгаа үрэлгээг Наран шарга агро ХХК-тай гэрээ байгуулан ажлыг хийж байна.



Аймгийн Засаг даргын А/537 тоот захирамжийг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд багийн нутаг дэвсгэрт малтай айлуудын судалгааг авч, хүргэн Баруун-Урт хотын төвд мал тэжээдэг өрхүүдийг дунд нийтийн сонсголыг Баруун-Урт сумын ЗДТГазраас зохион байгуулсан. Тус сонсголд малтай өрхийн төлөөлөл 20 гаруй иргэн оролцлоо. Нийтийн сонсголоор Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс, ИТХ-ын дарга Т.Ихбаяр, Аймгийн цагдаагийн газар, ОБГ, Мал эмнэлэг, Сүхбаатар тохижилт-Үйлчилгээ ОНӨҮГ, Ойжуулалт хайлаас ХХК зэрэг байгууллагууд мэдээлэл өгч, цаашид хотын төвд мал тэжээхгүй байх, хариулгатай байлгах, захиргааны ямар арга хэмжээг авагдаж байгаа талаар мэдээллийг өгсөн.

2023 оны хагас жилийн малын түүвэр тооллого 05 сарын 30-ны өдрөөс 06 сарын 06 өдрүүдэд явагдсан. Баруун-урт сумын хэмжээнд 289 малчин болон мал бүхий өрх түүвэр судалгаанд хамрагдсан. Тооллогод 4 группын 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, тооллогын ажлыг цаг тухайд нь хийж дуусгасан. 06 сарын 06-ны өдрөөс 06 сарын 14 өдрийг хүртэл мал тооллогын шивэлтийн ажил, хяналтыг хийж дуусгасан. Түүвэр тооллогоор 289 өрхийн 78296 мал тоологдсоноос адуу-8297, үхэр-6582, хонь-40473, ямаа-22872, тэмээ-72 тоологдсон байна.

2023 онд Баруун-Урт сумын хэмжээнд аймаг, сумын аварга малчин өрхөд ирүүлсэн материалуудыг эрэмбэлэн шаардлага хангасан материалыг Засаг даргын зөвлөлд танилцуулсан. Аймгийн аварга малчин өрхөд 4, сумын аварга малчин өрхөд 16, материал ирснээс аймгийн Засаг даргын 2022 оны А/615 дугаар захирамжаар аймгийн аварга малчин 4, сумын аварга малчин 14 тодорсон. Тус аймаг сумын аварга малчин өрхүүдэд шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт 2022 оны 12 дугаар сарын 05-аас 28-ны хооронд 10 иргэн нохойд хазуулж анхны тусламж авсан мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 06 -ний өдөр МЭГазарт мэдээллэж, галзуу өвчнөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарч ажиллах хүсэлт тавьсны дагуу холбогдох эмч, мэргэжилтэн нар хамтарч ажиллалаа.

Орон нутагт ЭМЯ-ны нийтийн эрүүл мэндийн газар, халдвар,халдварт өвчний хэлтсийн дарга багийн ахлагч Г.Ганхуяг, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма, ХӨСҮТ-ийн мэс заслийн тасгийн эрхлэгч Жавзандулам, ЗӨСҮТ-ийн тархвар судлаач Орломжав нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орон нутагт 2023 оны 01 дүгээр сарын 07,09-ний хооронд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан Мал эмнэлгийн газраас Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн холбогдох удирдлага, эмч мэргэжилтэн нартай 01 дүгээр сарын 08-ны өдрийн 17⁰⁵ минутад цахим хурал хийж мэдээ мэдээллийг солилцон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл гаргаж ажилласан. Цахим хуралд ЭМЯ-

ны нийтийн эрүүл мэндийн газар, халдвар,халдварт өвчний хэлтсийн дарга багийн ахлагч Г.Ганхуяг, ЗӨСҮТ-ийн тархвар судлаач Орломжав нар хамтарч оролцсон.

Холбогдох мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудтай зөвшилцөж ЭМГ, МЭГ, ОНӨААТҮГ, Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсэг гарсан.

Лабораторид ирсэн нохойн 8 дээжинд Солонгос улсад үйлдвэрлэсэн Rarid test kit тестээр шинжилгээ хийхэд бүгд сөрөг урвал үзүүлснийг холбогдох ажлын хэсэгт мэдэгдэж бүх дээжийг битүүмжлэн дагалдахын хамт УМЭАЦТЛ-д баталгаажуулах шинжилгээнд хүргүүлсэн.

Мөн Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 128 тоот албан бичгийн дагуу Сүхбаатар аймгийн мал эмнэлгийн газар, Сүхбаатар аймгийн ОНӨААТҮГ-тай хамтран тус иргэнд хохирол учруулсан 1 нохойг зориудын устгалд оруулан галзуу өвчний шинжилгээг Аймгийн Мал эмнэлгийн лабораторт өгч шинжүүлэн шинжилгээний хариугаар тухайн нохойноос галзуу өвчний үүсгэгч илрээгүй.

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгээс ирүүлсэн нохойд хазуулсан иргэд, дээрх нохойн эздийн нэр, байршлийг хүлээн авч, Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч, лабораторийн шинжлэгч эмч нартаа тархвар зүйн тандалт, дэгдэлтийн судалгаа, лабораторийн шинжилгээнд дээж материал авах, халдваргүйтгэл хийх талаар зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

2023 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн вакциныг захиалан бод, бог малыг хамруулахаар төлөвлөснөөс одоогоор боом-8.6 л, цусан халдварт-290,4л, шөвөг яр-19.3 мт, сахуу- 132 л вакциныг МЭГ-аас татан авч ААН-ийн эмч нарт захиалгын дагуу хуваарилан өгч ажилласан.

2023.04.19-ний өдөр Сүхбаатар сумын 4-р багийн нутаг “Хүүхдийн худаг ” гэх газар нутаглаж буй Баруун-Урт сумын 8-р багийн малчин М.Ганбатын сууриас гоц халдварт хонины цэцэг /A040/ өвчний сэжиг бүхий дуудлага ирсэний дагуу Аймгийн мал эмнэлгийн газар, Баруун-Урт сумын мал эмнэлгийн тасагт чиглэл өгч тухайн хот айлын мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хяналтандаа авах, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, өдөр тутмын халдваргүйтгэл хийх, өвчний шинж тэмдэгтэй малаас лабораторийн шинжилгээнд дээж материал арга зүйн дагуу авч ажиллахыг баг хариуцсан “Гүн Гуу” ББН-ний мал эмнэлгийн эмч Ч.Оюунчимэгт үүрэг өгсөн.

2023 оны 04 дугаар сарын 19-ны өдөр 15 цаг 40 минутад Гүн Гуу мал эмнэлгийн эмч Ч.Оюунчимэг, МЭГазрын их эмч Батбаяр нар хөдөлмөр хамгаалалын дэглэмийг сахин, малчнаас нь тархвар зүйн судалгаа авч, өвчний шинж тэмдэг бүхий-3 хурга байснаас 1-хургыг зориудын устгалд хамруулж стандарт арга зүйн дагуу шинжилгээний дээж авч Мал эмнэлгийн газрын лабораторид хүргүүлсэн. Үзлэгээр шинж тэмдэгтэй хурга нь нүд нуухадсан, 40-41°C халуурсан, номойрсон, толгой хавдсан, нимгэн арьстай хэсэгт гүвдрүү, цэврүү үүссэн шинж тэмдэгтэй байсан.



2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн сумын Засаг даргын А/116 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг тогтоон ажилласан.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 23-3195 тоот шинжилгээний хариугаар хонины цэцэг өвчний үүсгэгч илэрсэн. Үүний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн сумын Засаг даргын А/118 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг тогтоон ажиллалаа.

Мөнххаан сумын 1 дүгээр багийн нутаг “Бургастай” “Бортын” хоолойд гэх газар нутагладаг 8-р багийн малчин Д.Болдбаатар, Г.Отгонзоригт дуудлага ирсний дагуу баг хариуцсан “Ихэр-Жим” мал эмнэлгийн эмч Г.Гантогтох 16 цагт очиж дуудлагын дагуу хонинд үзлэг хийсэн. Үзлэгээр хонины цэцэг өвчний шинж тэмдэгтэй 12 хургыг ялган тусгаарлан, 1 хурганд задлан хийн шинжилгээний дээж материалыг арга зүйн дагуу авч Аймгийн мал эмнэлгийн лабораторид дээжийг хүргүүлэн ажилласан.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 05 дүгээр сарын 04-ны өдрийн 23-3389 тоот шинжилгээний хариугаар хонины цэцэг өвчний үүсгэгч илэрсэн.

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Мөнххаан сумын Засаг даргын А/73 тоот захирамжийг гарган Бургастай гэх газарт хорио цээрийн дэглэмийг тогтоосон.

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн А/145 тоот захирамжаар Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд шаардагдах хөрөнгийн зардлыг гамшгаас хамгаалах сангаас нийт-4.135,700төг-ийг шийдэж өгсөн.

Гоц халдварт хонины цэцэг өвчинтэй тэмцэхэд шаардагдах зардлыг сумын Засаг даргын А/118 тоот захирамжаар Хүүхдийн худгийн голомт болон хөдөлгөөнт постод ажилласан албан хаагчийн томилолт зардлыг гамшгаас хамгаалах сангаас нийт-2,973,800 төг-ийг шийдвэрлэсэн.

Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны 02 тоот тушаалаар батлагдсан малын гоц халдварт өвчний үед шалган нэвтрүүлэх цэгийн ажиллах зааврын дагуу Сүхбаатар сумын "Хүүхдийн худаг" гэдэг газарт гоц халдварт хонины цэцэг өвчинтэй холбогдуулан хөдөлгөөнт постод 8-н хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч, Аймгийн Онцгой ийг шийдсэн. байдлын газрын ахлах ахлагч Ж.Доржсүрэн, Цагдаагийн газрын дэд ахлагч Б.Отгонбаатар, ЗДТГазраас мэргэжилтэн 72 цагаар ээлж солигдон орох, гарах машины хөдөлгөөнийг зохицуулалт хийн бүртгэн, малчдад болон мал бүхий иргэдэд заавар зөвлөмжийг өгч, орсон гарсан нийт-225 машины дугуйг-4250м² ариутгал халдваргүйтгэлийг хийн, малын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавин холбогдох бичиг баримтыг шалган нэвтрүүлэн ажиллалаа.



Голомтод ажиллаж буй 2 малын эмч нь өдөр бүр мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийж, халдваргүйтгэлийг тогтмол хийж байна. Голомтод болон сэжигтэй бүсэд байгаа малчин өрхийн 14454 толгой малд эрүүл мэндийн үзлэг хийж, өвчний шинж тэмдэгтэй 3 - н хургыг зориудын устгалд хамруулан, үхсэн -43 хургыг устган ариутгал халдваргүйтгэлийг хийн ажилласан.



Голомттой бүсийн ариутгалд -16000 м², сэжигтэй бүс-30200м² нийт-46200 м² талбайд халдваргүйтгэлийг хийн ажиллалаа.

2023 оны 05 дүгээр сарын 16- ны өдрийн сумын Засаг даргын А/148 тоот захирамжаар “Хүүхдийн худаг ” гэх газрын хорио цээрийн дэглэмийг бууруулан хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн.

МЭГазраас цэцгийн вакцин -11,7 мян/ тун вакциныг авч, голомт болон сэжигтэй бүсийн малыг вакцинжуулахад Гүн-Гуу мал эмнэлэг 16 өрхийн хонь-5995, хурга-2660 нийт-8655 толгой малд, Ихэр-Жим МЭ- 2 өрхийн хонь-1228, хурга-264 нийт-1492 нийт-10147 толгой малд вакцинжуулалтыг хийн ажилласан.

Хонины цэцэг өвчний голомттой болон сэжигтэй малчин өрхийн судалгааг гарган МЭГазарт хүргүүлсэн.

МЭГазраас нэмэлт цэцгийн вакцин-28,0 мян/тун хүлээн авч, Гүн-Гуу мал эмнэлэгт-10,0 тун, Ихэр-Жим мал эмнэлэгт-10,0 тун, Жавхлант-Өлзийт мал эмнэлэгт-8,0 тун вакциныг хуваарилан өгч ажилласан. Вакцинжуулалтад 18 өрхийн хонь-7925, хурга-1796 нийт-9721 толгой малд тарилгыг хийж байна.

2023 оны 05 дүгээр сарын 30- ны өдрийн сумын Засаг даргын А/161 тоот захирамжаар “Хүүхдийн худаг ” газрын хязгаарлалтын дэглэмийг цуцласан. Эцсийн халдваргүйтгэлд-14654 м² Дүк машинаар хийсэн.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах үхэр, гахайны судалгааг гарган МЭГазарт хүргүүлэн ажиллалаа.

Шүлхий вакцинжуулалт хийхтэй холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дүгээр сарын 03-ны өдрийн А/128 тоот захирамж гарч, сумын гамшгаас хамгаалах нөөц сангаас бензинд-4,995,300 төг, туслах ажилчин-3,000,000 төг нийт- 7,995,300 төг-ний зардал тооцоог шийдсэн. Сумын хэмжээний үхэр-46262 толгой мал, гахайг -132 шүлхий дархлаажуулалтад хамруулахаар Мал эмнэлгийн газраас шүлхий вакцин-46.4 мян/тун хүлээн авч, ААН-6 мал эмнэлгийн малын эмч нарт хуваариалан өгч ажилласан.

Шүлхий вакцинжуулалтын явцын мэдээгээр өрх-268, үхэр-17655, гахай-32 нийт-17687 толгой малд вакцин хийгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/51 тоот тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 тоот, аймгийн Засаг даргын А/107 дугаар захирамж, хэрэгжилтийг хангах зорилгоор өвөлжилт, хаваржилтын хүндрэл, байгалийн

аюулт үзэгдлийн улмаас зүй бусаар хорогдсон малын хүүр, сэг зэмийг цуглуулах ажлыг зохион байгуулах хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр бууц хашаа байр, уст цэг, усны эх булгийг нийтийн эзэмшлийн гудамж талбайд цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах ажлыг сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны А/48 тоот захирамж гарч, Засаг даргын нөөц сангаас сэг зэм устгал, халдваргүйтгэл хийхэд шаардагдах зардалд-3205900 төг-ийг шийдвэрлэсэн.

2023 оны 05 дугаар сарын явцын мэдээгээр мал амьтны сэг зэмийн устгалд: Адуу-50, үхэр-87, хонь-540, ямаа-412, бусад амьтны-235 нийт-1324ш сэг зэмийг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж, хашаа хороо-14.8 м², өтөг бууц-6.5 м² худаг уст цэгт-1.8 м², агуулах зоорь-5.5 м², нийтийн эзэмшлийн-5.6 м², устгалын цэг-3.0 м² бэлчээрийн-10.2 м² талбайд нийт-47,4м² халдваргүйтгэлийг хийж ажиллалаа.

2023 оны 05 сарын 19-нд гамшгаар хорогдсон малын хүүр, сэг зэм устгах, халдваргүйтгэл хийх тухай Аймгийн Засаг даргын 05 дүгээр сарын 22-ны өдрийн 03 тоот албан даалгаврын хүрээнд малчдаас мал хорогдлын мэдээг авах, үхсэн малын сэг зэмийг цуглуулах ажилд ХАА-н тасаг болон мэргэжилтнүүд, Сумдын удирдлагууд, БЗДарга нар, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нар гар бие оролцон сэг зэмийг цуглуулан булж устган, ариутгал халдваргүйтгэлийг хийн ажиллалаа. Сумын малын хорогдол тэмээ -7, адуу- 3988, үхэр -3911, хонь -20338, ямаа -21431, бүгд 49675 толгой мал хорогдсон. Одоогийн байдлаар устгалын 8 цэгт, суудлын машин-4, ачааны машин-5, ковш-2, н-30 хүний бүрэлдэхүүнтэй устгасан мал: адуу -1106, үхэр- 1204, хонь -8115, ямаа -7948, бүгд-18373 толгой мал устгалд хамрагдан, халдваргүйтгэлд-42970 м², талбайд хийн, суперкилл 30 кг бодисийг зарцуулан ажилласан.

Шүлхий бог мал мялзан өвчний вакцины өмнөх тандалтад 3 өрхийн үхэр-12, хонь-36 малаас цус авч Мал эмнэлгийн газрын лабораторид өгч ажилласан.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах үхэр, гахайны судалгааг гарган МЭГазарт хүргүүлэн ажиллалаа.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим систем шинэчлэгдэж гарал үүслийн гэрчилгээг хариуцсан ААН-ийн тус бүрээр нь малчин өрхүүдийн нэрсийг цахимд шивж оруулан ажилласан.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хамрагдах малын тоог ААН-ийн 6-н мал эмнэлэгээс авч нэгтгэн МЭГазарт хүргүүлэн ажилласан.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга туулга, боловсруулалтад хамрагдах малчин өрхүүдийн нэрсийг ААН-н бүрээр цахим төлөвлөлтөд оруулан ажиллалаа.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хамрагдах малын тоог ААН-ийн 6-н мал эмнэлэгээс авч нэгтгэн МЭГазарт хүргүүлэн ажиллалаа. Туулгалтад хонь-3060, ямаа-2550, боловсруулалтад хонь-6250, ямаа-4350, бүгд-16210 толгой малыг хамруулаад байна.

Аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд хийсэн ажлын тайлан болон нохой судалгааг нэгтгэн МЭГазарт хүргүүлэн ажилласан.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний идэвхигүй тандалтад нийт-80 малчин өрхтэй утсаар ярьж мэдээллийг авч, судалгаанд хамруулан ажиллалаа.

2023.06.15-ны өдөр Сүхбаатар сумын 5-р багийн нутаг “Цогт” гэдэг газар нутаглаж буй Баруун-Урт сумын 4-р багийн малчин Ц.Энхбаатарын сууриас гоц халдварт хонины цэцэг өвчний сэжиг бүхий дуудлагыг утсаар 2023 оны 06 дугаар сарын 16 ны өдрийн 08 цаг 30 минутад Баруун-Урт сумын мал эмнэлгийн тасагт мэдээллэсэн. Үүний дагуу Аймгийн МЭГазрын МАЭМАлбаны даргад мэдэгдсэн.

Аймгийн мал эмнэлгийн газраас Нян молекул биологи шинжээч эмч О.Мөнхтулга, Ариун цэвэр магадлан шинжилгээний шинжээч эмч Ц.Тогосмаа, жолооч Б.Батэрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг лабораторийн шинжилгээнд дээж авах ажлаар, МЭГазрын мэргэжилтэн Э.Сүрэнжагдаг голомтод үзлэг тандалт, дархлаажуулалт хийх ажлаар, тархвар зүйч Д.Бямбасүрэн нь дэгдэлт, тандалт эрсдлийн судалгаа хийх ажлаар тус тус томилогдон ажилласан.

Дээрхи ажлын хэсэг сэжигтэй дуудлага өгсөн тухайн хотонд 2023 оны 06 дугаар сарын 16 -ны өдөр 08 цаг 50 минутад очиж халдвар хамгааллын хувцсаа өмсөж орсон.

Малчнаас нь тархвар зүйн судалгаа авч, тухайн малчны 360 хонинд эрүүл мэндийн үзлэг хийж өвчний шинж тэмдэгтэй 80 хонийг тусгаарлалтад авч, өвчлөж хүндэрсэн, эм хонь-1 лабораторийн шинжилгээнд болон зориудын устгалд хамруулан арга зүйн дагуу дээж материал авч, өвчний шинж тэмдэгтэй үхсэн 3 хонийг тухайн хот айлаас зайдуу үер усанд автагдахааргүй өндөрлөг газрыг сонгон нүх ухаж стандарт арга зүйн дагуу булж устган халдваргүйтгэл хийж, шинж тэмдэг үзүүлээгүй 280 хонинд цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хийж, хашаа, хороо, устгалын цэгийн 1850 м² талбайд



Нисор-оор халдваргүйтгэл хийн ажиллалаа. Үзлэг хийхэд шинж тэмдэгтэй хонины нүд нуухадсан, 40-41°C халуурсан, номойрсон, толгой хавдсан, нус гоожсон, нимгэн арьстай хэсэгт гүвдрүү үүссэн зэрэг шинж тэмдэгтэй байсан.

Лабораторийн шинжилгээнд задлангаар элэг цайрсан, дэлүү хэвийн, уушги цайвардуу гүвдрүүтэй, зүрх хэвийн, арьсан доорх ислэгт гүвдрүү үүссэн байсан. Өвчний шинж тэмдэгтэй нэг хониноос дээж шинжилгээ авч МЭГ-т хүргүүлэн ажилласан.



2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн сумын Засаг даргын А/178 тоот захирамжаар “Хязгаарлалтын дэглэм” тогтоон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 06 дүгээр сарын 19-ны өдрийн 23-4107 тоот шинжилгээний хариугаар хонины цэцэг өвчний үүсгэгч илэрсэн.


2023 оны 06 дүгээр сарын 19-ны өдрийн сумын Засаг даргын А/185 тоот захирамжийг гарган Цогт гэх газарт хорио цээрийн дэглэмийг тогтоосон.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж 4-р сарын 20-ны өдөр батлуулсан. Тодотголоор мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг тодотгосон. Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн аврах бүлгийн 30 албан хаагчийг байнгын бэлэн байдлыг хангаж 2 удаа хээрийн түймэрт явна гэсэн дуудлагаар шалгасан. Мөн байгаль цаг уурын гамшигт үзэгдлийн үед 1-р багийн нутаг дэвсгэрт Хангамжийн 8 айлын орон сууцны дээвэр хуурч 1 машины дээрээс унасан байсныг мэргэжлийн ангийн аврах бүлгийн 15 албан хаагч аюулгүй болгож ажилласан. 05-р сарын 19-ны өдөр болсон байгалийн гамшгийн аюулын үед болон гамшгийн дараах арга хэмжээнд Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн аврах бүлгийн албан хаагчид давхардсан тоогоор 120 албан хаагчид төөрч алга болсон иргэний дуудлага, гамшигт өртсөн малын сэг зэмийн устгал, барилга байгууламжийн дээврийг аюулгүй болгох зэрэг ажилд дайчлагдан ажилласан.

Сумын онцгой комиссын 1-р хуралдааныг хийж хаваржилтын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан 2 шийдвэрийг гаргасан. Үүнд: сумын аюулгүй нөөцөд тэжээл нэмэгдүүлэх, аюулгүй нөөцийн өвс тэжээлийг малчдад олгох талаар шийдвэр гаргасан. Гамшгийн нөөц сангаас 10,000,000 төгрөг, засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтээс 10,000,000 төгрөгийн санхүүжилтийг гаргаж 1250 шуудай хивэгийг Дорнод гурил ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч татан авалт хийсэн. Гамшгийн үеийн нөөцийг 40,0 сая.төгрөг ОНХСангийн хөрөнгөнд тусгуулж баталсан ба 4-р сард цэцэг өвчний вакцинжуулалт -3,0 сая төгрөг, цэцэг өвчний голомтод 4,2 сая.төг шүлхий өвчний дархлаажуулалтад зарцуулагдах шатахуун болон туслах ажилтаны ажлын хөлс 8,0 сая.төг, 1-р багийн хангамжийн 8-н айлын орон сууцны дээвэр засварт 3,0 сая төгрөгийг зарцуулаад байна. 5-р сарын 19-ны өдөр болсон байгалийн гамшгийн үеийн үхсэн малын сэг зэмийг устгах ажилд 17,9 сая.төгрөгийг тус тус хуулийн хүрээнд зарцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолоор "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газар хөдлөлтийн дадлага сургалтыг 2023 оны 06-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт Баруун-Урт сумын иргэдийг газар хөдлөлтийн үед аюулгүй талбайд 11 цэгт байршуулж нийт 9 багийн 2212 том хүн 343 хүүхэд тус сургуульд хамрагдсан. Тус ажлыг Баруун-Урт сумын онцгой комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, багийн ажлын алба хамтран зохион байгуулсан. Газар хөдлөлтийн үеийн дадлага сургуулийн үеэр нийт иргэдэд "Бэлэн бай" апплейкешнийг суртачилан таниулсан.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан байгалийн аюултай үзэгдэл 2023 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд болж, тус суманд салхины хурд 30м/с хүрч цасан болон шороон шуурга шуурч үзэгдэх орчин хязгаарлагдан аюултай нөхцөл байдал үүссэний улмаас иргэдийн эд хөрөнгө, мал амьтан, хүрээлэн буй орчин, барилга байгууламжид их хэмжээний хохирол учирсан.Хохиролын жагсаалтыг хавсралтаар гарган аймгийн Онцгой комисст хүргүүлсэн.



Гамшгийн нөхцөл байдлыг арилгах ажилд 23 төрийн байгууллагын 263 албан хаагч ажилласан. Тайлант сарын 25-ны байдлаар бод-1168, бог-19034, төл 2536 нийт 9 багийн 22738 мал хорогдоод байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:

Хагас жилийн байдлаар дараах хууль тогтоомжийг хяналтад авч, хугацаанд нь тайлагнаж, үр дүнг тооцож ажилласан байна.Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7 заалтыг хяналтад авч, биелэлтийг 6 удаа тайлагнасан.Биелэлт 74.2 хувьтай,

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 заалтыг хяналтад авч, 6 удаа тайлагнасан. Биелэлт 45.0 хувьтай,

Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 3 заалтыг хяналтад авч, 80 хувьтай тус тус хэрэгжсэн байна.

Байгууллагын даргаас гаргасан 286 шийдвэр, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан, зөрчилгүй эрх зүйн шийдвэр гаргаж хэвшсэн. Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хөтөлж байгаа бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэж байна.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар тус Тамгын газарт хандаж 1106 өргөдөл, гомдол ирсэн байна. Өргөдөл, гомдлын барагдуулалт 100%-тай байна. Тамгын газрын 1 дүгээр улирлын өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээг гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу дараах чиглэлээр дотоод хяналт хийж ажиллалаа. Үүнд:

-Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн, байгууллагын архивт хугацаандаа тушаасан байдал.

-Өөрийн хариуцсан салбар, эрхэлсэн ажлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хяналтад авсан эсэх.

-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдлыг

шийдвэрлэх журмын хэрэгжилтэд хяналт хийх.
Хяналтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгах талаар дараах зөвлөмжийг өгч ажилласан.

Үүнд:

Жилийн эхнээс ажлаа тодорхой шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон хүрэх түвшинтэй үр дүнд суурилсан төлөвлөлт хийж, тухайн жил хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхой тусган, биелэлтийг хангах талаар эрчимтэй ажиллах. үр дүнтэй зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцож ажиллах.

Төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд ил тод мэдээлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулах.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хууль, ЗГ-ын 2022 оны 201, 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахад онцгой анхаарах.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг хуралдуулж, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг шинэчлэн батлах.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, дүрмийг албан хаагчдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтэд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй хариу өгч, хугацаанд нь шийдвэрлэж хэвших.

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр эргэн мэдэгдэж байх.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын өргөдөл гомдол санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журмын хэрэгжилтийг ханган ажиллах. Дотоод хяналтад 5 тасгийн 28 албан хаагч хамрагдсан байна.

Аймгийн ХШҮ-ний цахим сангийн ашиглалтыг хариуцан зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь тайлагнахад хяналт тавьж ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 5 удаа тайлагнасан. Үүнд:

1 дүгээр сард 55 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 87,9%

3 дугаар сард 3 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 73,3%

4 дүгээр сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 77.4%

5 дугаар сард 5 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 78.5%

6 дугаар сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 78.5 % тус тус тайлагнасан байна.

Хугацаа хэтэрсэн тайлан байхгүй.

Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг хариуцан ажиллуулж, гүйцэтгэл үр дүнг тооцон ажиллаж байна. Хагас жилийн байдлаар 12 албан хаагчийн мэдээллийг шинэчилж, 8 албан хаагчийн алдааг залруулж ажилласан. Хагас жилийн байдлаар 39 албан хаагч цахим сан ашиглах эрх үүссэн. Үүнээс 36 албан хаагч ашиглаж байна. 3 албан хаагчийн эрх хүчингүй болсон. Цахим сан ашиглах заавар, зөвлөгөөг тухай бүр өгч ажилладаг. Цахим санд Тамгын газрын даргаас 18 албан хаагчдад 16 удаа үүрэг өгөгдсөн. 3 албан хаагч хугацаа хэтэрч тайлагнасан. 13 албан хаагч хугацаандаа тайлагнасан.

Сумын Засаг даргын 2023 оны А/162 тоот захирамжаар томилогдсон 2 ажлын хэсэг сумын харьяаны 17 байгууллагад 3 өдөр хяналт шинжилгээ үнэлгээг дараах чиглэлд хийсэн. Үүнд:

1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

2.Тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилт

3.Тушаалын хууль эрх зүй үндэслэл

4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

- 5.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайлан
6. Байгууллагын төсөв, санхүү, тендер, хөрөнгө оруулалт
- 7.Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөө, хэрэгжилт
- 8.Цаг үеийн асуудлаар өгсөн үүргийн биелэлт
- 9.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хяналтад авсан байдал

Хяналтыг газар дээр нь цаасан болон цахим суурьтай баримт бичгийг нягтлан үзэх, хариуцсан албан тушаалтан, албан хаагчаас асууж тодруулах зэргээр хийлээ.Чиглэл бүрд илэрсэн зөрчлийг арилгах арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлсэн. Хяналтын шинжилгээ үнэлгээ хийсэн тухай тайланг сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Мөн албан тушаалтан, албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, удирдах албан тушаалтанд уламжилж ажиллалаа. Өмнө жилийн ХШҮ-ний тайлан, дүгнэлттэй харьцуулахад байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэлт бүрд ахиц гарсан байна. Бусдад түгээх сайн туршлагууд цөөнгүй байна. Жишээ -Өндөр эрсдэлтэй 120 хүүхдийн судалгааг гарган 24 хүүхдэд кейс нээж ажиллаж байна.

-11 дүгээр цэцэрлэг:Тайлангуудыг QR коджуулсан байна. Олон Улсын төсөл хөтөлбөрөөс хөрөнгө оруулалт татсан.

1-р сургууль: Эрсдэлт бүлгийн 270 өрхөд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хүүхэд хөгжил хамгааллын сургалтын зохион байгуулж эрсдэлийг бууруулах мэдээлэл хийсэн. Мөн эрсдэлт бүлгийн 270 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 2-3 дах шатлалын эмнэлэгт -11 хүүхдийг холбон зуучлан ажилласан байна.

2-р сургууль: Хүүхэд хөгжлийг дэмжих жилийн хүрээнд төлчин сурагч, намрын ажил, сурагч цэрэг, бид сайн үйлстэн, өв тээгчтэй уулзах цаг зэрэг арга хэмжээг санаачлан зохион байгуулсан байна.

2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг байгууллагын мэдээллийн цагаар нийт албан хаагчдад мэдээлж, холбогдох мэргэжилтэнд хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар тусгайлан зөвлөгөө өгч ажилласан.Мөн согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж ажилласан. 2023 онд шинээр гарсан болон нийтлэгээр хяналтад авах ёстой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн талаар харьяа төсөвт байгууллагын дарга, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.

Тус сумын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтад хяналт тавин ажиллаж байна.

Хагас жилийн байдлаар:

1-р сард 29 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 30 заалтыг 87.09

3-р сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7 заалтыг 74.2

4-р сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7 заалтыг 77.14

5-р сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 6 заалтыг 73.3

6-р сард 7 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7 заалтыг 78.5 тус тайлагнасан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг

3-р сард 6 заалтыг 36%

4-р сард 6 заалтыг 32%

5-р сард 6 заалтыг 46%

6 сард 6 заалтыг 46% тус тус тайлагнасан. 2023 оны хагас жилийн байдлаар 9 төрлийн мэдээг тайланг хүргүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Дээрх хууль тогтоомжийн удааширсан болон тасарсан заалт арга хэмжээг хяналтад авч үр дүнтэй зохион байгуулахыг албан хаагчдад зөвлөж ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай 2023 оны 02 дугаар сарын 10-нд 6 бүлэг 64 арга хэмжээ нийлүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээг байгууллагын мэдээллийн цагаар албан хаагчдад танилцуулан, төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөсөн.Цахим файлыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд байршуулсан. Мөн холбогдох албан хаагчид тухай бүр биечлэн сануулсан.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний өөрт хамаарах 6 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангаж ажиллана. Хагас жилийн байдлаар хэрэгжилт 84% тай байна.Үүнд:

-Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг тухай бүр зохион байгуулах.Хэрэгжилт-50%

-Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаас сумын засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хуралд хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гарган, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.

-Харьяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаанд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

-Архины архаг хэрэглээтэй болон орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх ажлыг холбогдох төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлэх-

-2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

Аймгийн ХШҮ-ний тасгаас ирсэн удирдамжийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна.

Хөтөчөөр ажиллах иргэдийн судалгааг гарган аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан. Эрх зүйн хөтөч нартай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан танхимын сургалтад хамрагдан гэрчилгээ авсан.

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст зохион байгуулах сургалтын саналыг хүргүүлж, төлөвлөгөөнд нь тусгуулсан.

-2023 онд шинээр гарсан хуулийн танилцуулга РР Тамгын газрын албан хаагчдад мэдээллийн цагаар мэдээлэл хүргэж ажилласан. Нийт 53 албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан.

-Байгууллагын дотоод зөвлөгөөнд оролцсон нийт албан хаагчдад сумын хэмжээнд мөрдөх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулсан.

-Харьяа төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт Зөв хэвшил-зөв амьдрал хөтөлбөрийг танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай захиалгатаар нийлүүлсэн.

-Тус сумын хэмжээний сэтгэл зүй, сэтгэл судлаач нарт хөтөлбөр, түүний зорилт, бодлого, чиглэлийг танилцуулсан.

Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг байгууллагын дотоод зөвлөгөөнөөд нийт

албан хаагчдад, төсөвт байгууллагын зөвлөгөөнөөр сургууль, цэцэрлэг, ОНӨААТҮГазруудыг захирал, эрхлэгч, дарга нарт хөтөлбөр, түүний зорилт, бодлого, чиглэлийг тус тус танилцуулсан.

Сэтгэл зүйч, сэтгэл судлаач мэргэжилтэй иргэдийн судалгааг гарган, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уулзалтад оролцсон иргэдэд Зөв хэвшил-зөв амьдрал хөтөлбөр, Монгол өрх ТББ-аар хийлгэсэн судалгааны дүнг тус тус танилцуулсан бөгөөд цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон. Уулзалт 7 иргэн хамрагдсан. Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.Үүнд:

-Сэтгэл зүйн төвтэй болох ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаа эхлээд явж байна.

-Амьдрах сайхан " тв нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд амьдралын зөв хэвшил дадал олгохыг ажлыг зохион байгуулсан.Уг нэвтрүүлгийг 16к иргэн үзсэн. -Өсвөр насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол, хувийн санхүүгээ удирдах буюу хэрэглээ хүслээ ялган таних, хуримтлалын талаар зөв ойлголттой болох, гар утасны хэрэглээний аюул, боломжийн талаар мэдлэг ойлголт олгох сураглтыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр ерөнхий боловсролын 2, 4 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн 16 бүлгийн 314 сурагчдад зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолоор “ Хүүхдийн хөгжил, хамгаалал”-ыг дэмжих жил болгон зарласан, мөн “Зөв хэвшил-Зөв амьдрал” аяны хүрээнд 2023 онд сэтгэлзүйн чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулахаар болсонтой холбогдуулан өсвөр насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол, хувийн санхүүгээ удирдах буюу хэрэглээ хүслээ ялган таних, хуримтлалын талаар зөв ойлголттой болох, гар утасны хэрэглээний АЮУЛ-БОЛОМЖ-ын талаар сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 10, 13-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 1, 2, 4 дүгээр сургуулийн 6, 7, 9 дүгээр ангийн нийт 16 бүлгийн 314 сурагчдад амжилттай зохион байгуулсан.

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 4-р сарын 19-ний өдрийн А/112 тоот 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага, халалтын ажлыг зохион байгуулах тухай захирамжийн дагуу 05 сарын 1,2-ны өдрүүдэд 76 хүний бүрэлдхүүнтэйгээр 2 өдрийн турш цэрэг татлагын ажлыг зохион байгууллаа.Баруун-Урт сумын 18-25 насны нийт 470 иргэнд цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл өгч ажилласнаас 192 иргэн эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж Жанжин штабын тогтоосон хяналтын тооны дагуу тэнцсэн цэргүүд Дорнод аймгийн 0132 дугаар ангид хугацаат алба хаахаар хуваарилагдлаа.

МУ-ын Засгийн газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулагдлаа.Уг хэлэлцүүлэгт Тамгын газрын болон харъяа төсөвт байгууллагын албан хаагчид хамрагдаж саналаа өгсөн.



Нийгмийн даатгалын багц хуулинд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт сумын иргэдийг хамруулж, санал, бодлыг нь тусгуулан хамтран ажиллалаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын чиглэлээр: Сумын Засаг даргын 2023 оны А/48 тоот захирамжаар хаврын бүх нийтийн цэвэрлэгээг 03 дугаар сарын 25-26, 3 дугаар сарын 30-31 өдрүүдэд Баруун-Урт сумын 1,2,3,4,5,6,9-р багийн нутаг дэвсгэрт зохион байгуулж тус Тамгын газрын 40 албан хаагчид багуудад хувиарлагдан айл өрхөөр орж, цэвэрлэгээний зарыг хүргэн айл өрх, иргэдийг цэвэрлэгээнд гарган хог хаягдлын зөөврийг 14 машин/портер/, 26 ачигчтайгаар хийж, 78 удаагийн ачилтаар 124,5 тн орчим хог хаягдал, шарилжийг хогийн цэгт зөөвөрлөн хаяж нийт 46 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллалаа. Мөн байгууллага, ААН, ЕБС-н сурагчид хаварын их цэвэрлэгээнд хамрагдан өөрийн харьяа газарт болон ногоон хашаанаас гадуур тархасан хог хаягдлыг цэвэрлэн хогын цэгт хаяж ажиллалаа.

Шинээр хийгдэх 7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах худалдааны гудамжны тохижилтын ажлын зураг төсөв, 1 дүгээр багийн тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажил, 3 дугаар багийн тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажил, 9 дүгээр багийн нутаг дэвсгэр байрлах хяналтын камерын систем холбох ажлын зураг төсвийн ажлыг Батсүндрэл ХХКомпанитай хамтран гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар 5 дугаар сарын эхний 7 хоногийг мод тарих өдөр болгон зарласантай холбогдуулан орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр 30 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13000 ширхэг модны усалгаа арчилгааны тендерийг зарлаад байна.

5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах хуучнаар 10 айлын нийтийн орон сууцны дээвэр засварын ажлын тендерт Молцог Элс ХХКомпани шалгарч тус ажлыг хийж гүйцэтгэн комиссоор хүлээн аваад байна.

7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах жаргалант хотхоны 8 айлын голын талбайн тохижилтын ажил, 2 дугаар багийн нутаг дэвсгэр саруул хотхоны гадна тохижилтын тус бүр 60.0 сая төгрөгийн төсөвтэй тендерүүдийг зарлаад байна.

7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн орон сууц Одкон хотхоны 2,3 байр, 276 байрны дээвэр засварын 180.0 сая төгрөгийн төсөвтэй дээвэр засварын ажилд Нар Сар Газар ХХКомпани тендерт шалгарч гэрээний дагуу тус ажлуудыг эхлүүлээд байна.

8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах ХАА-н паркийн 25 га газрын гадна талын хамгаалалтын торон хашаа татах ажлын трасс болон эргэлтийн цэгүүдийн тавих хашаа татах ажлыг хийж гүйцэтгэсэн.

8 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Хайлааст үүдэнд байрлах үйлдвэрийн бүсийн 200га газарт хэсэгчилсэн төлөвлөлт хийх ажлын тендерт инженер геодези ХХКомпани шалгарч тус ажлыг газар дээр нь шалгах зураг төсвийн боловсруулалт хээрийн судалгааны ажлыг өнгөрсөн оны 11 сард хийж гүйцэтгэн зураг төсвийг сум болон аймгийн удирдлагуудад урьдчилсан байдлаар танилцуулж ажилласан.

1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Амгалан хороололд дахин төлөвлөлт хийх ажлыг Land Over ХХК хийж тендерт шалгарч хийж гүйцэтгэж байгаа ба тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн 3 удаа хуралдаж тус ажлыг гүйцэтгэж байна. Эхний ээлжинд иргэдээс санал авах зах зээлийн судалгааг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд иргэнд газар эзэмшүүлэх сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор нийт 4 иргэнд

газар эзэмших эрх шилжүүлэх захирамжийг сумын засаг даргын захирамжаар гарган газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн.

3.4.5.9 дүгээр багийн нутаг байрлах зөөврийн болон шугамын усан санд ухаалаг систем тоног төхөөрөмж суурилуулах ажлын тендерт Баялаг говь ХХКомпани шалгарч гэрээний дагуу тоног төхөөрөмж угсрах ажлыг хийж гүйцэтгэн 5 худагт тоног төхөөрөмж суурилуулан нэмэлт нэг худгийн тоног төхөөрөмжийг зөөвөрлөх шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ногоон байгууламж, байгаль орчны чиглэлээр: Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Сүхбаатар аймгийн Засаг даргын А/277 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын А/42 тоот захирамжаар 86 аж ахуй нэгж, байгууллагыг хуваарийг гарган баталсан.

Багийн нутаг дэсвгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд 1/193 тоот албан тоотыг 50 ш багийн Засаг дарга, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нарт гарган өгч хүргүүлсэн. Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд

2023 оны тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг 05 сарын 11-12 өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Тус үзэсгэлэн худалдаанд:

Ойжуулалт-хайлааст ХХК, Жимст тал хоршоо, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨҮГ, Грийн



Твийн Вийт ХХК, Онгон Мөнххаан сумаас өрхийн үйлдвэрлэгч 2 иргэн оролцож 18 төрлийн мод бут, сөөгний суулгац, 6 төрлийн мандлын цэцэгний үрсэлгээ, зүлэгний үрийг олон нийтэд хүргэж 10 сая төгрөгийн тарьц суулгацын борлуулалт хийгдсэн.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр 05 сарын 13-ны өдөр 45 байгууллага тарилтыг ажлыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн ЗД-с өгсөн үүрэг чиглэлийн дагуу Соёл амралтын хүрээлэнгийн голын татам дагуу мод тариагүй байгууллагуудыг хувиарлан 1800 гаруй бургасны тарилтын ажлыг зохион байгуулсан.



Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги ахмадын сувилалын дагуу 5000 ш хайлаас, мод үржүүлгийн газартаа улиас 86000 мянга, бургас 8300, улиангар 50.000, хайлаасны үрээр 2022 онд 15 кг, 2023 онд 12 кг тарьсан.

Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ААТОНҮГ газар 2023 онд мод үржүүлгийн газартаа харандаа, үрээр 15230 ш улиас, агч-600, гүйлс-300, буйлс-200, хайлаас-10000 ш тарьсан.

Баруун-Урт сумын ЗДТГазраас ногоон байгууламж, хашлага хайсыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Боловсрол төгөлийн хашааг тэлэх, Асгатын зам дагуу 1 га газрыг хашаажуулах арга хэмжээг авсан.

Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн боловсронгуй болгох төслийн санхүүжилтээр Баруун-Урт сумын 2 дугаар баг Баруун-Уртын голын ай савд 8 га газарт татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалах 645 м хашааны шонгийн нүхийг ухах, гагнуурын ажлыг хийж гүйцэтгэсэн. Голын гольдрилын бэхэлгээ, хаалга, суурь цутгалтын ажил дутуу байна. 215 ш хашаа, 216 ш шонгийн гагнуурын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2.7 сая төгрөгийн зардал гарсан.

Баруун-Урт сумын ЗДТГазраас зарласан ногоон байгууламжийн усалгаа арчилгааны багц-1 буюу 16,1 сая төгрөгийн тендерт Шаргын модод ХХК шалгарч усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Багц-2 буюу 13,9 сая төгрөгийн тендер 3 удаагаа зарлагдаж, гэрээ байгуулах шатандаа явж байна.

Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ААТОНӨГазар сум дундын ойн ангиас хүлээн авсан тойргийн мод, төвийн ногоон байгууламж, наадмын талбай зэрэг 8000 гаруй модны усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна.

Мөн ЗДТГазраас ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн санал хүсэлтийн дагуу Хэнтийн аймгийн Хурх жибуур ХХК-тай гэрээ байгуулж 1096 ш модны худалдан авалт хийж, иргэдэд олголоо. Нийт 71 иргэн 300 гаруй мод хөнгөлөлттэй үнээр мод авсан. Мөн хотын төв зам дагуу 1.5 м-с дээш өндөртэй гоёлын 37 ш нарс модыг тарьсан.

Баруун-Урт сумын Агропарк 4000-5000 ш модны тарилтын ажлыг зохион байгуулж байна.

Өнөөдрийн байдлаар 70 ААН, байгууллага, 600 иргэн 34257 ш модыг тариад байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Шууд худалдан авалтын журмаар 10 ажил, харьцуулалтын аргаар 10 ажил, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2 ажлыг тус тус tender.gov.mn сайтаар 100 хувь цахимаар зарлан зохион байгуулсан.

Нийт 21 ажлын 957,250.6 мянган төгрөгийн гэрээ байгуулж 139,086.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

2023 оны төсөвтэй холбоотой мэдээллийг тухай бүр мэдээллийн сувгуудад байршуулсан. Үүнд:

1. УМСистем
2. Шилэн дансны систем
3. tender.gov.mn
4. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар пэйж хуудас
5. Төсвийн ил тод байдал төсвийн инцо апплейкшн
6. Зурагт слайд
7. Орон нутгийн BBS телевиз
8. baruun.urt.su.gov.mn

- 9.Багуудын пэйж хуудас
10. Сүхбаатарын өнгө
11. Багийн иргэдийн нийтйн хурал
12. Орон нутгийн хөгжлийн сангийн пэйж хуудас гэх мэт.

Худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn сайт, байгууллагын пэйж хуудсаар дамжуулж 16 ажлын урилга, зууны мэдээ сонинд 5 урилга, ERF системд 16-н удаагийн урилгыг 100 хувь байршуулсан. Байгууллагын мэдээлэл байршуулдаг сувгийн тоо 10 байна.

Мөн шилэн данс, удирдлага мэдээллийн систем, tender.gov.mn сайтуудыг тухай бүр, сар бүр тогтмол хөтлөн ажиллаж байна

Үнэлгээний хороо байгуулах захирамж нийт 12-ийг байгуулсан байна. Үүнд:

- 1.Ухаалаг худгийн тоног төхөөрөмж А/42,
2. Явган зам нэмэгдүүлэх А/53,
3. Худалдааны гудамжны тохижилтын ажил А/50,
4. Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа А/51,
5. Жаргалан хотхоны гадна талбайн тохижилтын ажил А/55,
6. Саруул хотхоны гадна талбайн тохижилтын ажил А/54,
7. Агуулах авто граж худалдан авах А/103,
8. 1 дүгээр багийн тоглоомын талбайн засвар А/106,
9. 3 дугаар багийн тоглоомын талбайн засвар А/107,
10. Зөөврийн сууц худалдан авах А/109,
11. Камержуулалтын нэгдсэн систем байршуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах А/114,
12. Ундны ус нөөцлөх 1000м3, 2000м3 усан санг доторлох, битүүмжлэл сайжруулах А/152 зэрэг нийт 12 захирамж байгуулсан.

Үнэлгээний хорооны гишүүдээр ажиллах зөвшөөрсөн мэдүүлэг 9 н албан хаагч, 2 ИНБ-ын төлөөлөл, мэргэжлийн байгууллагын 2 төлөөллийг давхардсан тоогоор оролцуулж 60 мэдүүлэг бөглүүлсэн.

Үнэлгээний хороо 12 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг 12 удаа хуралдаж боловсруулсан.

Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсөв, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, аймгийн орон нутгийн төсвөөр батлагдсан 13 ажлын нарийн бичгийн ажиллаж tender.gov.mn сайтаар 28 удаагийн давтамж зарлан зохион байгуулсан.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 12 дугаар сарын 29-ний өдрийн 15/12 тоот тогтоолоор 2022 оны хөрөнгийг бүртгэлжүүлсэн.

Нийт 16 нэр төрлийн ажил 410,1 сая төгрөгийн хөрөнгийг хурлын тогтоолоор баталгаажуулсан.

Нэмэлт 2 ажил 40,0 сая төгрөгийг тамгын газрын тайланд, орон нутгийн хөгжлийн сангийн тайланд 256,0 сая төгрөгийг хөрөнгийг бүртгэлжүүлсэн.

Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, уртын гэгээ ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГ, Дөрвөлж ААТҮГ, Цагдаагийн газар, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр, Ерөнхий боловсролын 1 р бүрэн дунд сургууль зэрэг байгууллагуудад данс бүртгэлд тусгуулсан.

Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар эрх шилжиж ирсэн Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээвэр засварын ажлыг / Одкон хотхон 1,2 дугаар байр, 27 в байр / 2022 онд 1 удаа зарлаж амжилтгүй болж 2023 онд 1 удаа зарлаж гүйцэтгэгчээр Нар сар газар ХХК 167,192.9 мянган төгрөгөөр шалгарч ажлыг А/159 тоот захирамжаар

хүлээн

авсан.

Зуны сувилал байгуулах ажлын хүрээнд зөөврийн сууц худалдан авах ажлыг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулж гүйцэтгэгчээр Оточ оргил ХХК 119,800,000 төгрөгөөр шалгарч бараа хүлээн авах шатандаа явагдаж байна.

Нэгдсэн систем нэвтрүүлэх камержуулалтын нэгдсэн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулж тендерт 5 компани оролцож тендер үнэлгээний шатандаа явагдаж байна.

Ундны ус нөөцлөх 1000м³, 2000м³ усан санг доторлох, битүүмжлэл сайжруулах ажил дээр сумын засаг даргын А/152 тоот захирамжаар байгуулаад байна.

Харъяа төсөвт 15 байгууллага 100 хувь цахим системд төлөвлөгөө байршуулж 1-2 удаа зарлан зохион байгуулсан байна. 1 дүгээр сургууль 3 багц, 3 дугаар сургууль 3 багц, 4 дүгээр сургууль 5 багц, 3 дугаар цэцэрлэг 7 багц, 7 дугаар цэцэрлэг 2 багц, 8 дугаар цэцэрлэг 2 багц, 9 дүгээр цэцэрлэг 3 багц, 10 дугаар цэцэрлэг 3 багц, 11 дүгээр цэцэрлэг 2 багц, нийт 9 байгууллагын 25 багцад Өсөх дэлгэр ундрах ХХК 378,070.2 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна. Үдийн цай хөтөлбөр болон хоол хүнсний тендерт хууль эрх зүйн хүрээнд цахимаар мэдээлэл хүргэх болон биеэр арга зүйн зөвлөгөөг 5 удаа өгч ажилласан. -Сумын Засаг даргын 2023 оны А/162 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж удирдамж төлөвлөгөөний дагуу сумын харьяаны төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ -уудын эхний хагас жилийн ажлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг 06 дугаар сарын 06-08 -ны өдрүүдэд хийж ажилласан. Хуваарийн дагуу 1, 4,5,6,8,9 дүгээр цэцэрлэг, Уртын гэгээ ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлтийн ойн анги зэрэг 9 байгууллага дээр ажлын хэсгийн хамт ажиллаж газар дээр зөвлөн туслах арга хэмжээг 1 удаа үзүүлсэн. Мөн ажлын хэсэгт зөвлөмжийн саналыг хүргүүлсэн

Шилэн дансны системд сар бүр оруулах бүлгийн 2 заалт, тухай бүр оруулах бүлгийн 2 заалтад хуулийн хугацаанд 100 хувь бүрэн оруулсан. Шилэн дансны системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Шилэн дансны тухай хуулийн 4.1.9 – т зааснаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулсан бол тендерийн ерөнхий мэдээлэл, 5,0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мэдээлэл, ОНХС-гийн хэрэгжилт, аудитын дүгнэлт,

Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу ОНХСан, ХХСан 2022 санхүүгийн тайланг CTS программ ашиглан гаргаж аудитын байгууллагад хүргүүлж нэгтгэсэн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.

Баруун урт сумын харъяа 503 аж нэгж байгууллага санхүүгийн тайланг гаргалт дээр зөвлөгөө өгч 2022 оны санхүүгийн тайлан гаргалт 90% тай ажилласан.

Харъяа төсөвт 8 байгууллага нь дулааны тоолуур байршуулж, хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажилласан.

Татварын болон татварын бус орлого 3,334.5 сая төгрөг орж, орлогын төлөвлөгөө 100% биелэсэн байна.

Төсөт байгууллага-18, ОНӨААТҮГ-3 нийт 21 байгууллагад 2,867.2 сая төгрөгийн санхүүжилтийг ЗЭБ-1 маягт хөтлөн олгож үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

2023 оны батлагдсан төсвийг байгууллагын орлого зарлагын уялдааг харгалзан тооцож төсвийг сар тус бүр дээр хувиарлан хуулийн хугацаанд гаргаж батлуулсан. Тамгын газрын нийт батлагдсан төсөв-856,230.1 төгрөг, Үйлчилгээний нэгдсэн төвийн батлагдсан төсөв-647,913.4 төгрөг, орон нутгын нөөц сан-120,000,000.0

төгрөг, Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал-495,000,000.0 төгрөг тус тус батлагдсан байна.

Байгууллагын бараа материалыг орлого зарлагын анхан шатны баримтыг үндэслэн тухай бүр санхүүгийн програмд бүртгэсэн. Төрийн сангийн төлбөр тооцооны цахим Портал систем нэвтэрсэнтэй холбогдуулан бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж байгууллага бүртэй бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ, хамтран ажиллах шинэчилсэн гэрээг байгуулан ажилласан. Нийт 12 аж ахуй нэгж, төрийн байгууллагатай гэрээ байгуулсан байна.

Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем болон төрийн сангийн төлбөр тооцооны цахим Портал системийг шинэчлэлтэнд 100 хувь хамрагдсан.

2023 оны хагас жилийн байдлаар /1270.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 2,752.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэй байна./ Хувь хүнээс авах авлага 1,270,000.00 төгрөг нь Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2017 оны 12 дугаар сарын 05-ны Д/31-01/86 тоот актаар тогтоосон Баруун-Урт сумын ЗДТГ-т ажиллаж байсан нэр бүхий ажилтан албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод он дамжуулан суутган тооцоогүйгээс үүссэн авлага юм.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал

